



СУРГУУЛЬ -ЭЦЭГ ЭХТЭЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭ

Нэг талаас Улаанбаатарын Бритиш Дунд Сургууль (цаашид “Сургууль”) нөгөө талаас ”Эцэг эх буюу албан ёсны асран хамгаалагч” нар харилцан тохиролцожовогтой-г цаашид ”Сурагч” –ийг тус сургуульд элсүүлэн сургахаар энэхүү гэрээг байгуулав.

1. Доор дурьдсан нэр бүхий хүмүүс ар гэрийг төлөөлж хүүхдээ сургуулиас авна:

Овог нэр	Сурагчийн хэн болох

- Сурагч нь сургуульдаа өдөр бүр ирэх ёстой ба Сургуулийн дотоод дүрэм, журмыг чанд мөрдөнө.
- Би/Бид (”Сурагч”, ”Эцэг эх буюу асран хүмүүжүүлэгч”) Энэ хичээлийн жилийн Сургуулийн бүртгэлийн журамтай уншиж танилцсан ба аливаа нэмэлт өөрчлөлт гарсан тохиолдолд тухай бүрт сургуулиас бидэнд албан ёсоор мэдэгдсэний дагуу хүлээн авч мөрдөх болно. Бидний талаас төлбөрийн аль нэгэн нөхцлийг биелүүлээгүй тохиолдолд “Сурагч” хичээлдээ үргэлжлүүлэн суух боломжгүй болохыг ойлгож байна.
- Холбоо барих, оршин суух хаяг өөрчлөгдсөн тохиолдолд “Сургууль”-д даруй мэдэгдэнэ.
- Сурагчийг өөр сургуульд шилжүүлэх/сургуулиас гаргах тохиолдолд хичээлийн жилийн олон нийтэд гаргасан хуваарийн дагуу нэг бүтэн улирлын өмнө “Сургууль”-д бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү бичгээр мэдэгдэлгүй сурагчийг сургуулиас гаргах ба шилжүүлэх тохиолдолд хичээлийн бүтэн улирлын төлбөрийг бүтнээр төлнө.
- Сурагч нь ноцтой хэрэгт холбогдож буруутай нь тогтоогдвол “Сургууль” нь ямар ч сануулга өгөлгүйгээр сургуулиас шууд хасах эрхтэй. Ийм тохиолдолд сургалтын төлбөр эргэн төлөгдөхгүй болно.
- Би/Бид сургуулийн хэрэгцээнд зориулж хүүхдийнхээ фото зургийг авахуулахыг зөвшөөрч байна.
- Элсэх өргөдөлд сурагчийн эрүүл мэндийн тухай мэдээллийг үнэн зөв бөглөсөн ба ямарваа нэгэн өөрчлөлт гарсан тохиолдолд сургуульд тодорхой мэдээлэл өгөх болно.
- Би/бид Эцэг эх буюу асран хүмүүжүүлэгч”) сурагчийг сургуулийн зохион байгуулж буй бүхий л арга хэмжээнд /аялал, экскурс г.м./ оролцуулахыг зөвшөөрч байна. Хичээлийн танхимаас гадуур зохион байгуулагдах арга хэмжээнд хүүхдээ оролцуулахад сургуулийн хүсэлтийн дагуу эцэг эх бичгээр зөвшөөрөл олгоно.
- Би/бид өөрсдийн хүсэлтээр Сурагч-ийг тус сургуульд сургаж буйгаа үүгээр хүлээн зөвшөөрч байна. Сургууль нь сурагч бүрийн аюулгүй, бүрэн бүтэн байдалд аюул учруулж болох аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх хүний хүчин зүйлээс хамаарах бүхий л нөхцлийг хангана. Сургуулиас гаргаж буй дээд зэргийн хүчин чармайлтаас үл хамааран сурагч сургуульд ирэх, буцах болон сургуульд байх хугацаанд ямар нэгэн гэмтэл ба бэртэлд өртөх тохиолдолд сургууль өөрсдийн зүгээс авч болох боломжтой бүхий л арга хэмжээг авах ба харин үүнтэй холбогдон гарч болох эмнэлгийн төлбөр ба бусад ижил төстэй зардлыг сургууль хариуцахгүй. Түүнчлэн хувийн зүйлсээ гээж, үрэгдүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээхгүй болно.
- Би/бид үүгээр сургуулийн ажилчид шаардлагатай үед сурагчид эмнэлгийн анхны тусламж болон эмнэлэгт үзүүлэхийг зөвшөөрч байна. Ямар ч тохиолдолд бид эхлээд эцэг эхтэй холбоо барих болно. Сургууль нь аливаа эмнэлэг, эмчилгээний зардыг хариуцахгүй болно.
- Хэрэв би/бид өөр улсруу явах болвол, тухайн хугацаанд сурагчийг асран хамгаалах хүний холбоо барих мэдээлэл болон бичиг баримтын хуулбарыг сургуульд авчирч өгөн, мэдээлэх болно.

Би/,” Эцэг эх буюу асран хүмүүжүүлэгч” тус хамтын гэрээг уншиж танилцаж, ойлгосон бөгөөд сургуулиас гэрээнд хийгдэх нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөх болно.

Эцэг эхийн гарын үсэг: _____ Эцэг эхийн гарын үсэг: _____ Огноо: _____